



Үндэсний аудитын газрын харьяа
Хэнтий аймгийн аудитын газар

ҮАГ-ГАГ/2015/05-ГА-ХЭ

**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ЭВДЭРСЭН
ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТЭД ТАВИХ ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**



11/2/2015

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн ҮАГ-ын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Аудитын менежер: Б.Наранцэцэг Шинжээч: Д.Эрдэнэбилэг Б.Мөнгөнцэцэг 2015 оны 05 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147, 98332147 тоот утас, 70562112 факсаар харилцана уу. Хаяг: Хэнтий аймаг Хэрлэн сум АЗДТГ-ын байр. 325 тоот өрөө	Агуулга	
	Товчилсон үгийн тайлбар	
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	
	Ерөнхий мэдээлэл	
	Нэгдүгээр бүлэг: Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байна.	
	Аудитын дүгнэлт 1	
	Хоёрдугаар бүлэг: БОНХАЖЯам барьцаа хөрөнгийг буцаан олгодоггүй тул зарцуулалт тодорхой бус байна.	
	Аудитын дүгнэлт 2	
	Гуравдугаар бүлэг: Уул уурхайн нөхөн сэргээлтэд тавих төрийн хяналт сул байна.	
	Аудитын дүгнэлт 3	
	Аудитын зөвлөмж	
	Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн холбогдох байгууллагын санал	
	Аудитын тайлангийн баталгаажуулалт	
	Аудитаар илэрсэн зөрчил ба акт, албан шаардлагын жагсаалт.	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧЛОСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
БОНХАЖЯ	Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын яам
УИХ	Улсын Их Хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ШШГА	Шүүхийн Гийдвэр Гүйцэтгэх Алба
ААН	Аж Ахуйн Нэгж
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
УБҮ	Уулын баяжуулах үйлдвэр
БОМ	Байгаль орчны менежмент
БОГУУХУАБ	Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Нэг: Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 17-ны 20 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий Аудитор Төндөсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Тэргүүлэх Аудиторын 2015 оны 1 дүгээр сарын 27-ны 05 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Хоёр: Аудитын зорилт

Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт нь хууль, тогтоомжийн дагуу хийгдэж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг тэргүүлэх аудитор, аймгийн Засаг дарга болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдлээ.

Дээрхи зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ. Үүнд:

- Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх,
- Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх,
- Төр, орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх,
-

Гурав: Аудитын хамарсан хүрээ

Аудитаар 2013-2014 онд “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн биелэлтийг аймгийн БОАЖГ, аймгийн МХГ-ын тайлант жилүүдэд хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаархи тайлан, мэдээ, ажлын баримт материал, шинжилгээний үнэлгээ дүгнэлтийг ашиглаж Бор-Өндөр, Дархан, Батноров, Баян-овоо Норовлин, Хэрлэн, Баянхутаг сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Дацан трейд” ХХК, “Баян-Эрдэс” ХХК, “Бэрх-Уул” ХК, “Адуляргео” ХХК, Хан шашир” ХХК, “ГОК Булган-Уул” ХХК, “Тулга-Өгөөж” ХХК, “Дорнын нүүрс” ХХК, ШШГА-ны 0419-р анги, Бор-Өндөрийн УБҮ, “Лут чулуу” ХХК, “Монфайненс” ХХК, “Жинхуа орд” ХХК, “Си Эм Кэй Ай” ХХК-дийг хамруулсны зэрэгцээ Норовлин сумын нутаг дахь гар аргаар алт олборлогчдын нөлөөгөөр сүйдсэн газрын нөхөн сэргээлт хийсэн байдлыг газар дээр нь шалгалаа.

Дөрөв: Аудитын арга зүй, стандартын талаах мэдээлэл

Аудитад Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга хийх, судалгаа гаргуулах, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглахаас гадна аудитын хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу аудитын дүнд дэмжлэг болох нотлох зүйл цуглуулж, судлан тайлан бэлтгэв.

Тав: Аудит хийсэн хугацаа:

Аудитын төлөвлөлтийг 2015 оны 9 дүгээр сарын 1-ээс 10-ны хооронд, талбарын ажлыг 9 дүгээр сарын 14-аас 10 дугаар сарын 15-ны хооронд тус тус хийж, тайлагнах ажлыг 10 сарын 15-аас 20-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

Зургаа: Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль эрхийн акт, бодлогын бичиг баримтыг эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Газрын хэвлийн тухай хууль,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль,
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам,
- Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой стандартууд:
- MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт,
- MNS5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал,
- MNS5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн шаардлага,

Долоо: Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аудитын менежер Б.Наранцэцэг хянан удирдаж, ахлах аудитор Н.Туяа ахлан, шинжээч Д.Эрдэнэбилэг хийж гүйцэтгэлээ.

Найм: Хүндрэл бэрхшээл:

Аудитын явцад аймгийн МХГ, “Дорнын нүүрс” ХХК-ны холбогдох албан тушаалтнууд аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй, “Хавтгай”-н нүүрсний уурхай дээр очиж шалгахад уурхайн удирдлагууд байхгүй, баримт материал гаргаж хамруулаагүй, аймгийн Аудитын газарт ирж уулзах хүсэлт тавихад ирээгүй нь аудитыг бүрэн хийхэд тодорхой бэрхшээлтэй байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь Стандартчилал Хэмжил зүйн газраас баталсан 4 стандартаар, байгаль орчныг нөхөн сэргээх хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт нь Ашигт малтмалын болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудаар болон уул уурхайн асуудал эрхэлсэн яам, агентлагаас гаргасан дүрэм, журмаар зохицуулагдаж байна.

2013 оны байдлаар Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт хайгуулын 116 тусгай зөвшөөрлийг 400,9 мянган га талбайд, ашиглалтын 91 тусгай зөвшөөрлийг 33,9 мянган га талбайд нийт 207 тусгай зөвшөөрлийг 434,8 мянган га-д олгосон бол 2014 онд хайгуулын 69 тусгай зөвшөөрлийг 170,8 мянган га талбайд, ашиглалтын 97 тусгай зөвшөөрлийг 44,4 мянган га талбайд нийт 166 тусгай зөвшөөрлийг 215,2 мянган га-д олгосон байна.

2015 оны 5 сарын 3-ны байдлаар уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч ААН, байгууллагууд Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт хайгуулын 65, ашиглалтын 100 тусгай зөвшөөрлөөр нийт 183,3 мянган га буюу аймгийн нутаг дэвсгэрийн 2,2%-ийг уул уурхайн зориулалтаар ашиглаж байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээр 17 ААН уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулснаас аудитад 12 ААН-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтээр хийгдсэн ажлыг газар дээр нь шалгалаа.

Шалгалтад хамрагдсан ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа ААН-дээс “Жинхуа орд” ХХК, “Лут чулуу” ХХК, “Бор-Өндөрийн УБҮ”, “Баян-Эрдэс” ХХК, “Бэрх-Уул” ХК, “Дацан трейд” компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан, байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө буюу 2013 онд 94.8 сая.төг, 2014 онд 122,3 сая төгрөгийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны нөхөн сэргээлтийн дансанд байршуулсан бол аудитад хамрагдсан ААН-дээс 2013 онд 6 ААН, 2014 онд 7 ААН-ийн барьцаа хөрөнгө байршсан мэдээлэл байхгүй байна.

Хэнтий аймагт уул уурхайн үйл ажиллагаа явагдсан талбайгаас 2013-2015 онд 80,7 га-д техникийн, 40,8 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн бол 2010 оноос хойш нийтдээ 186,9 га-д техникийн, 70,5 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

**НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ**

**•УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХӨРӨНГИЙГ
БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.**

1.1 Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг холбогдох хуулийн дагуу тооцож байна.

Аудитад хамрагдсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 12 ААН-ийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг тооцсон байдлыг тухайн тусгай зөвшөөрөлтэй талбайн 2013-2014 онд хийгдэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөн дээрээс шалгаж үзэхэд дараах аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”**-ийн 9.10-т¹ заасны дагуу тооцсон байна. Үүнд:

д/д	ААН-ийн нэр	Хамаарах он	Байршуулах хөрөнгийн дүн /сая.төг/	Байршуулсан хөрөнгө /сая.төг/	Зөрүү /сая.төг/
1	Бор-Өндөр УБҮ	2013	45,9	46,8	+0,9
2	Бэрх-Уул ХК	2013	17,5	17,5	-
3	Баян-Эрдэс ХХК	2013	7,8	7,8	-
4	Дацан трейд ХХК	2013	14,6	10,4	-4,1
5	Жинхуа орд ХХК	2014	26,8	36,1	+9,3
6	Лут чулуу ХХК	2014	50,4	65,0	+14,6
7	Бор-Өндөр УБҮ /баргилт/	2014	13,1	13,1	-
8	Баян-Эрдэс ХХК	2014	8,0	8,1	+0,1
	ДҮН		184,2	204,9	24,9/4,2

БОНХАЖЯам нь урьд онуудад байршсан барьцаа хөрөнгийг дараагийн онуудад шилжүүлэх зарчмаар тооцож байгаа нь зарим аж ахуйн нэгжүүдийн барьцаанд илүү буюу дутуу хөрөнгө байршсан байдлаар харагдаж байна.

Аудитын явцад “Монфайненс” ХХК, “Дорнын нүүрс” ХХК, “ГОК Булган-Уул” ХХК, “Си Эм Кэй Ай” ХХК-ууд нь уурхай дээрээ хариуцах ажилтангүй, бичиг баримт байхгүй, аудитад хамруулах хүсэлт тавьсан боловч аудитын хугацаанд баримт бичгийг ирүүлээгүй зэргээр аудитад хамруулах боломжгүй байлаа.

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг дараа онд шилжүүлэн тооцож байгаа нь Байгаль орчин Ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар баталсан **“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд** хяналт **тавих журам”**-ын 3.1²-т заасныг баримтлахгүй, журмыг хэрэгжүүлээгүй зөрчил үүсч байна.

Харин Улаанбаатар хотын харъяалалтай хайгуулын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд аудитаар сумдад ажиллаж байх хугацаанд үйл ажиллагаагаа түр зогсоосон байсан нь

¹ 9.10.Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

² 3.1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлсэн бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгоно.

байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон бусад баримт материалыг аудитад хамруулан шалгах, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгчид тус хуулийг баримталж буй эсэхийг нягтлах боломжгүй байлаа.

1.2 Зарим ААН-ийн уул уурхайн нөхөн сэргээлтэд байршуулсан хөрөнгийн дүн тодорхойгүй байна.

Аудитын шалгалтад хамрагдсан ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 12 ААН-дээс “Жинхуа орд” ХХК, “Лут чулуу” ХХК, “Бор-Өндөрийн УБҮ”, “Баян-Эрдэс” ХХК, “Бэрх-Уул” ХК, “Дацан трейд” ХХК-ууд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулан, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө 2013 онд 94.8 сая.төг, 2014 онд 122,3 сая төгрөгийг Байгаль орчин аялал жуулчлалын яамны нөхөн сэргээлтийн дансанд бүрэн байршуулсан нь холбогдох санхүүгийн нотлох баримтаар бүрэн нотлогдож байна.

Сумдад ажиллах явцад аудитад хамрагдсан ААН-дээс 2013 онд 6 ААН, 2014 онд 7 ААН-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан эсэх нь тодорхойгүй, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршсан мэдээлэл байхгүй байна.

Нөхөн сэргээлтийн барьцааны мэдээлэл байхгүй ААН-үүд

д/д	ААН-ийн нэр	Он
1	Жинхуа орд ХХК	2013
2	Лут чулуу ХХК	2013
3	Си Эм Кэй Ай ХХК	2013
4	Монфайненс ХХК	2013
5	Дорнын нүүрс ХХК	2013
6	ШШГА 0419-р анги	2013
7		

д/д	ААН-ийн нэр	Он
1	Бор-Өндөр УБҮ	2014
2	Монфайненс ХХК	2014
3	Дорнын нүүрс ХХК	2014
4	Дацан трейд ХХК	2014
5	Бэрх уул ХК	2014
6	ШШГА 0419-р анги	2014
7	Си Эм Кэй Ай ХХК	2014

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдээс сумдын ЗДТГ-ын Төрийн сангийн “Байгаль хамгаалах сан”-д байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дүнг аймгийн ЗДТГ-ын СТСХэлтээс авч тайланд хамруулав.

Аймгийн нутаг дэвсгэрт 2013 онд хайгуулын 116 тусгай зөвшөөрөл олгогдсон бол 2014 онд 69, 2015 оны 9 сарын байдлаар 63 болж буурсан байна.



2014 оны байдлаар хайгуулын үйл ажиллагаа явуулсан 27 ААН хайгуулын ажлын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 8894,0 мянган төгрөгийг үйл ажиллагаа явуулсан сумдын байгаль хамгаалах дансанд төвлөрүүлсэн байна.

Уул уурхайн ААН-ийн үйл ажиллагаанд орон нутгийн төрийн байгууллага, аймгийн БОАЖГ, МХГ-ын шалгалт хангалтгүй хийгддэгээс аудитад хамрагдсан ААН-дээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүйгээс гадна нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулахгүйгээр үйл ажиллагаагаа явуулахад хүргэж байна.

Энэ нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 39.1.6³-д заасан бичиг баримт батлагдаагүй байхад ААН-үүд үйл ажиллагаагаа явуулсаар байхад аймаг, сумын төрийн байгууллагууд дээрхи хуулийн 39.6-⁴д заасан арга хэмжээг аваагүй нь орон нутгийн төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулж байна гэж үзэхээр байна. Жишээ нь:

- а. Бор-Өндөрийн УБҮ нь усны төлбөр 1,3 тэрбум төгрөгийг төлөх санхүүгийн боломжгүй байдалтай он дамжуулан удсанаас Хэнтий аймгийн комисс 2013, 2014 оны байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авахаас татгалзсан нь тус үйлдвэр сүүлийн 2 жилд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн хөрөнгө байршуулалгүй үйл ажиллагаа явуулахад хүргэсэн байна,
- б. Бэрх-Уул ХК нь 2013 оны уулын ажлын төлөвлөгөө хугацаа хоцорч гарснаас байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2013 онд батлаагүй, мөн 2014 онд нөхөн батлахгүй гэсэн, 2013 оны БОМ төлөвлөгөөний биелэлт гараагүй тул 2014 оны БОМ-ийн төлөвлөгөө, тайланг боловсруулах боломжгүй

³ 39.1.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

⁴ 39.6.Энэ хуулийн 39.5-д заасан хугацаанд мөн хуулийн 39.1.9-д заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй.

болсноос сүүлийн 2 жил БОМ-ийн төлөвлөгөөгүй, нөхөн сэргээлтийн хөрөнгө байршуулалгүй үйл ажиллагаа явуулсан байна.

1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн мэдээлэл бүрэн биш байна.

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн БОНХАЖЯамны төрийн сангийн дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн 2013, 2014 оны орлогын хуулга болон аудитаар ажилласан сумдад үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн санхүүгийн баримтанд тулгалт хийх аргаар шалгалтыг хийлээ.



Аудитад хамрагдсан 12 аж ахуйн нэгжээс 2013 онд 5, 2014 онд 4 ААН-ийн нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө санхүүгийн баримтаар батлагдаж байгаа бол үлдсэн ААН-д холбогдох санхүүгийн баримтыг аудитын явцад ирүүлээгүй тул барьцаа хөрөнгө байршуулсан эсэх нь тодорхойгүй байна.

Мөн БОНХАЖЯамнаас гарган ирүүлсэн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө тушаасан 2013, 2014 оны төрийн сангийн хуулгийг хянаж үзэхэд дараахи шалтгааны улмаас хүндрэлтэй байдал үүсэж байна. Үүнд:

- Шилжүүлсэн мөнгөний утганд лицензт талбайн дугаарыг тавиагүйгээс олон байршилд лицензтэй ААН-ийн хувьд уг талбайн барьцаа мөн эсэхийг тогтоох боломжгүй,
- Зарим ААН нь урьд оны барьцаа хөрөнгийг он дамжуулан тооцож байгаа тохиолдолд 2013, 2014 оны хуулгаас барьцаа хөрөнгө бүрэн харагдахгүй байх,

Ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа боловч нөхөн сэргээлтийн хөрөнгө байршуулсан эсэх нь тодорхойгүй ААН-үүд

Сумдын төрийн санд байрлалтай байгаль хамгаалах дансан дахь хайгуулын ажлын

д/д	ААН-ийн нэр	Үйл ажиллагаа явуулдаг сум	Ашигт малтмалын төрөл	Нөхөн төлбөр байршуулаагүй он	Нөхөн төлбөр байршуулаагүй шалтгаан
1	Дорнын нүүрс ХХК	Баянхутаг	нүүрс	2013, 2014	Аудитад хамрагдахаас зайлсхийсэн
2	ШШГА-ны 0419-р анги	Баянхутаг	Тоосгоны шавар	2013, 2014	2013, 2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй
3	Жинхуа орд ХХК	Бор-Өндөр	Төмөр	2013	Санхүүгийн баримтыг гаргаж өгөөгүй
4	Лут чулуу ХХК	Бор-Өндөр	Төмөр	2013	Санхүүгийн баримтыг гаргаж өгөөгүй
5	Си Эм Кэй Ай ХХК	Бор-Өндөр	Жонш	2013	Санхүүгийн баримтыг гаргаж өгөөгүй
6	Монфайненс ХХК	Бор-Өндөр	Жонш	2013, 2014	Санхүүгийн баримтыг гаргаж өгөөгүй
7	Дацан трейд ХХК	Норовлин	алт	2014	Санхүүгийн баримтыг гаргаж өгөөгүй
8	Бэрх-Уул ХХК /Чандган/	Мөрөн	нүүрс	2014	2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй
9	Монгол росцветмет ХХК	Бор-Өндөр	жонш	2014	2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй

нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн байршуулалт, нөхөн сэргээлтийн тайлан ирүүлэх тухай аймгийн Аудитын газраас 2015 оны 9 сарын 16-ны №173, 10 сарын 6-ны №193 албан тоотоор удаа дараа мэдэгдсэн боловч аудитын хугацаанд Цэнхэрмандал, Галшар, Баянхутаг, Батноров, Бор-Өндөр, Өмнөдэлгэр, Биндэр, Дархан сумд, Бэрх хотоос хариу ирүүлж бусад сумдын Засаг дарга нар тогтоосон хугацаанд хариу ирүүлээгүй нь “Төрийн аудитын тухай” хуулийн 21,1⁵ -д заасан үүргээ биелүүлээгүй байна.

Аудитын дүгнэлт 1

1. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хуульд заасан хувиар тооцож байна.
2. Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулаагүй боловч үйл ажиллагаа явуулсан байна.
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй нь техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй байхад хүргэж байна.
4. Хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа ААН-дийн байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил тодорхойгүй байна.

⁵ 21.1. Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй

**ХОЁРДУГААР
БҮЛЭГ**

**•БОНХАЖЯ БАРЬЦАА ХӨРӨНГИЙГ БУЦААН
ОЛГОДОГГҮЙ ТУЛ ЗАРЦУУЛАЛТ ТОДОРХОЙ БУС
БАЙНА.**

2.1 Төвлөрүүлсэн барьцаа хөрөнгөөс нөхөн сэргээлтэд зарцуулсан тохиолдол байхгүй байна.

Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нь барьцаа хөрөнгийг БОНХАЖЯ-ны нөхөн сэргээлтийн дансанд төвлөрүүлж байгаа ч өөрийн хөрөнгөөр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж, дараа жилийн төлөвлөгөөгөө БОНХАЖЯ-нд батлуулдаг тул аудитын шалгалтын явцад байршуулсан барьцаа хөрөнгөөр нөхөн сэргээлт хийсэн тохиолдол гарсангүй.

Харин БОНХАЖЯ-нд төвлөрүүлсэн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн санхүүгийн баримтыг аудитад хамруулах боломжгүй байсан тул нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн зарцуулалтын талаар тайлагнах боломжгүй байна.

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан ААН-үүдийн сумдын Төрийн сан дахь байгаль хамгаалах сангийн дансанд байршуулсан барьцаа хөрөнгөөр 2013-2014 онд нөхөн сэргээлт хийсэн тохиолдол байхгүй байна.

2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим ААН-д үйл ажиллагаагаа зогсоосон байна.

Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай 2013 оны байдлаар 116 буюу 400,9 мянган га байсан бол 2014 онд 69 тусгай зөвшөөрөлтэй 170,8 мянган га талбай болж, 2015 оны эхний 9 сарын байдлаар 65 тусгай зөвшөөрөлтэй 149,6 мянган га болж буурсан байна.

Харин 2013 онд ашиглалтын 91 тусгай зөвшөөрөлтэй 33,9 мянган га талбай байсан бол 2014 онд 97 тусгай зөвшөөрөлтэй 44,4 мянган га талбай болж 2015 оны эхний 9 сарын байдлаар 100 тусгай зөвшөөрөлтэй 33,6 мянган га талбай болж буурчээ

2015 оны 9 сарын байдлаар нийт 166 тусгай зөвшөөрлөөр 183,3 мянган га талбай буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 2,3%-ийг уул уурхайн хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:


д/д	Он	Зөвшөөрлийн төрөл	Лицензийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Аймгийн нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	2013	Хайгуулийн ТЗ	116	400,9	5,0
		Ашиглалтын ТЗ	91	33,9	0,4
		ДҮН	207	434,8	5,4
2	2014	Хайгуулийн ТЗ	69	170,8	2,1
		Ашиглалтын ТЗ	97	44,4	0,6
		ДҮН	166	215,2	2,7
3	2015.09	Хайгуулийн ТЗ	65	149,6	1,9
		Ашиглалтын ТЗ	100	33,6	0,4
		ДҮН	165	183,2	2,3

Түүхий эдийн үнэ огцом буурсан, Монгол улсад шинээр баталсан хуулиас хамаарч үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болсон, хөрөнгө оруулалт дутагдсан зэргээс шалтгаалан зарим ААН-үүд үйл ажиллагаагаа түр зогсоосон байна. Үүнд:

- а) Гадаад зах заал дээр жоншны үнэ унасны улмаас олборлон боловсруулах үйл ажиллагаа явуулдаг зарим ААН-үүд 2014 оноос үйл ажиллагаагаа түр зогсоосон байна. Жнь: “Зө-Юүе” ХХК, “Баянтэгш импекс” ХХК зэрэг,
- б) Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт байхгүйгээс “Бэрх-Уул” ХК жонш олборлох, “Чандган коул” ХХК нүүрс олборлох үйл ажиллагаагаа тус тус түр зогсоосон,
- в) **“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн үйлчлэлээр доорхи ААН-дийн үйл ажиллагаа 2013 оноос түр зогссон байна. Үүнд: Батширээт сумын нутагт “Айвуун тэс” ХХК, “Ю энд Би” ХХК, Өмнөдэлгэр сумын нутагт “Алтай хангайн бүрд” ХХК зэрэг болно,**

2013 оны байдлаар ашиглалтын 91 талбайд тусгай зөвшөөрөл авсны 70 буюу 76,9%, 2014 оны байдлаар ашиглалтын 95 талбайд тусгай зөвшөөрөл олгогдсоны 74 буюу 77,9%-д үйл ажиллагаа явуулаагүй байна.

2015 оны 9 сарын байдлаар Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээр 104 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсоны 84 талбай буюу 80,7%-д үйл ажиллагаа явагдаагүй байна.



2.3 Төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан эсэхийг шалгах боломжгүй байна.

Байгаль орчин Ногоон хөгжил Аялал жуулчлалын яамны нөхөн сэргээлтийн дансанд төвлөрүүлсэн уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-дийн барьцаа хөрөнгийн зарцуулалтын талаар баримт, материал байхгүй тул шалгах боломжгүй байна.

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээр 2014 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан 27 ААН-ээс 12 сумын байгаль хамгаалах сангийн дансанд төвлөрүүлсэн 8894,0 мянган

төгрөгөөс Дархан сумын байгаль хамгаалах сангаас зарцуулалт байхгүй бол бусад сумдад уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орсон талбайд барьцаа хөрөнгөөр нөхөн сэргээлт хийсэн тохиолдол байхгүй байна.

Мөн сумдын ЗДТГ-аас тухайн онд байршуулсан барьцаа хөрөнгийг ААН-д буцааж олгосон болон нөхөн сэргээлтийн ажилд зарцуулсан гүйлгээ байхгүй бөгөөд сумдын байгаль хамгаалах санд төвлөрдөг бусад зардалтай хамт ойжуулалт, суулгац, шатахуунд зарцуулсан байна.

Аудитын дүгнэлт 2

1. Аудитад хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн БОНХАЖЯ-нд байршуулсан барьцаа хөрөнгөөр нөхөн сэргээлт хийгдээгүй байна
2. Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлаа сайн хийж байна.
3. БОНХАЖЯ-нд байршуулсан нөхөн сэргээлтийн хөрөнгийг дараа оны барьцаа хөрөнгөнд шилжүүлэн байршуулж байгаа нь Байгаль орчин Ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар баталсан **“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 3.1-тэй нийцэхгүй байна.**
4. Ашиглалт болон хайгуулын лицензтэй дийлэнх ААН-үүд үйл ажиллагаа явуулаагүй байна.

**ГУРАВДУГААР
БҮЛЭГ**

**•УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТЭД ТАВИХ
ТӨРИЙН ХЯНАЛТ СУЛ БАЙНА.**

3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийсэн байна.

Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2013 онд 7 ААН 24,5 га-д техникийн, 10,3 га-д биологийн нөхөн сэргээлтийг, 2014 онд 7 ААН 13,2 га-д техникийн, 8,0 га-д биологийн, 1,5 га-д дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэн, аймгийн комисст актаар хүлээлгэн өгсөн нь баримтаар нотлогдож байна.

Үүнээс Норовлин суманд алт олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй “Баян-Эрдэс” ХХК, “Дацан трейд” ХХК-ууд нь техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг сайн гүйцэтгэхийн зэрэгцээ БОМ-ийн төлөвлөгөөнд тусгагдсанаас илүү нөхөн сэргээлтийг гүйцэтгэж байгаа сайн тал байна.



2013 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

д/д	ААН-ийн нэр	Нөхөн сэргээлтийн төрөл	Талбайн хэмжээ /га/	Тайлбар
1	Жин Хуа Орд ХХК	Биологийн	0,1 га талбайд 0,8 сая.төг-ийн олон наст ургамал тариалсан	Орд нь босоо уналттай учир хаалтын дараа бүрэн нөхөн сэргээлт хийнэ.
2	Бэрх-Уул ХК /Чандган/	Биологийн	0,35 га-д 835 ш хайлаас, улиас тарьсан	50 м хүртэл гүнтэй нүүрсийг бүрэн ашигласны дараа нөхөн сэргээлт хийгдэнэ
3	Бэрх-Уул ХК /тохой булаг/	Техникийн	14,1 га-д хийсэн	Цаашид 7,02 га-д техникийн, 69,52 га-д биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай
4	Хонг чанг ли ХХК	Техникийн	0,7 га-д хийсэн	Төлөвлөгөөнөөс 0,2 га-д илүү хийсэн
5	Баян-Эрдэс ХХК	Техникийн, биологийн	0,6 га-д техникийн, 0,5 га-д биологийн	
6	Дацан трейд ХХК	Техникийн, биологийн	5,7 га-д техникийн, 6,6 га-д биологийн	
7	Бор-Өндөр УБҮ	Техникийн, биологийн	3,2 га-д техникийн, 2,7 га-д биологийн	
8	Нордвинд ХХК	Техникийн	0,2 га-д	

2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

д/д	ААН-ийн нэр	Нөхөн сэргээлтийн төрөл	Талбайн хэмжээ /га/	Тайлбар
1	Бор-Өндөр УБҮ /Баргилт/	Дүйцүүлэн	Бор-Өндөр сумын төвд 1,5 га-д 1000 ш хайлаас суулгасан	БОХ төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажил тусгагдаагүй
2	Хан шашир ХХК	Техникийн	2 га-д хийсэн	Төлөвлөгөөнөөс 0,5 га-д дутуу хийсэн
3	Жих хуа орд ХХК	Биологийн	0,1 га-д үржил шимт хөрсний нөхөн сэргээлт хийсэн	Орд нь босоо уналттай учир хаалтын дараа бүрэн нөхөн сэргээлт хийнэ.
4	Дацан трейд ХХК	Техникийн, биологийн	8,4 га-д техникийн, 5,7 га-д олон настын үр цацаж биологийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийг 3,2 га-д, биологийн нөхөн сэргээлтийг 0,85 га-д илүү хийсэн байна
5	Нордвинд ХХК	Техникийн	0,15 га-д хийсэн	0,05 га-г дутуу хийсэн байна
6	Лут чулуу ХХК	Техникийн	0,1 га-д техникийн	
7	Баян-эрдэс ХХК	Техникийн, биологийн	2,5 га-д техникийн, 2,2 га-д биологийн	

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээр 2015 оны 9 сарын байдлаар лицензээр олгогдсон талбайд 5085,9 га, эзэнгүй орхигдсон 248,0 га, гар аргаар алт олборлогчдын нөлөөгөөр сүйдсэн 37,8 га нийтдээ 5371,7 га талбай эвдрэлд орсон байна.

Жил бүрийн “Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд” зарцуулах хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлаж, уг хөрөнгөөр 2013-2015 онд дэс дараатайгаар уурхайн үйл ажиллагаанд орж орхигдон, эвдэрсэн газруудад нийтдээ 43 га газарт 157,0 сая.төг нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн байна.

д/д	Орхигдсон газрын нэр	Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээлт хийсэн он	Талбайн хэмжээ /га/	Зардлын дүн /сая.төг/
1	Цэнхэрмандал сумын Баянмод багийн Бургастай	Техникийн, биологийн	2013	5 га	42,0
2	Норовлин сумын Салхит	техникийн	2014	22 га	30,0
3	Норовлин сумын Салхит	Техникийн, биологийн	2014	6 га	70,0 Азийн банкны ХО-аар хийгдсэн
4	Норовлин сумын “Өвдөг ухаа”	Техникийн, биологийн	2015	10 га	15,0 Хийгдэн байна.

3.2 Орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагуудын зүгээс байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

Аудитын явцад лицензээр олгогдоогүй Баянхутаг сумын “Сондуульт”-ын шаврын ордоос ШШГЕГ-ын харъяа хорих 0419 анги 2013-2014 онд зөвшөөрөлгүйгээр тоосгоны шавар олборлон 0,3 га газрыг, Хэрлэн сумын нутаг “Дулааны энгэр”-т 2 газар хайрганы олборлолтыг ашиглалтын зөвшөөрөлгүйгээр явуулж 2,5 га талбайг эвдрэлд оруулж нөхөн сэргээлт хийгээгүй зэрэг зөрчилд ямар нэг арга хэмжээ авч тухайн газрын нөхөн сэргээлтийг хийлгээгүй байна.



Энэ нь “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 2.4⁶-т заасан үүргээ аймгийн Засаг дарга хэрэгжүүлээгүй, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 2.1⁷ дэх заалтыг аймгийн МХГазар, “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 12 дугаар 1.2⁸ дэх заалтыг Баянхутаг сумын Засаг дарга биелүүлээгүйгээс дээрхи ААН-үүд зөвшөөрөлгүй талбайгаас ашигт малтмал олборлож ашиг олох, байгаль орчныг эвдрэлд оруулан нөхөн сэргээхгүй байдалд хүргэж байна.

Мөн Баянхутаг сумын нутаг “Хавтгайн” нүүрсний ордод олборлолт явуулдаг “Дорнын нүүрс” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон нөхөн сэргээлтийн барьцаа байршуулсан эсэх талаар тодорхой баримт ирүүлээгүй, ҮАГ-аас ирүүлсэн баримтанд барьцаа байршуулсан мэдээлэл байхгүй, аудитад хамруулахаар уулзах хүсэлт тавихад ирээгүй, очиход байгаагүй зэрэг нь тус компанийн байгаль орчныг хамгаалах үүргийн биелэлтийг үнэлэх боломжгүй байдалд хүргэсэн.

Дээрхи уул уурхайн ААН-дийн үйл ажиллагаанд хийгдэх Мэргэжлийн хяналтын шалгалт хангалтгүй, аймгийн МХГ-аас энэ чиглэлээр хийсэн хяналт, шалгалттай холбоотой

⁶ 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

⁷ байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

⁸ 12.1.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;

баримт, материалыг аудитад хамруулахаар ирүүлээгүй, холбогдох байцаагчдаас тодруулга авахаар уулзахыг хүсэхэд ирээгүй зэрэг нь тус байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхгүй байгааг харуулж байна.

Аудитаар илэрсэн зөрчил

д/д	ААН-ийн нэр	Талбайн нэр, дугаар	Зөрчил
1	Бор-Өндөрийн УБҮ	174А Бор-Өндөр	2013, 2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй
2	Бэрх-Уул ХК	4590А Чандган	2013, 2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй
3	ШШГЕГ-ийн харъяа хорих 0419-р анги	-	Лицензээр олгогдоогүй талбайд 2013, 2014 онд олборлолт явуулж 0,3 га-г эвдрэлд оруулсан
4	Дорнын нүүрс ХХК	4872А	Аудитад баримтаа хамруулаагүй
5	Аймгийн МХГ	-	Аудитад баримтаа хамруулаагүй
6		-	Лицензээр олгогдоогүй талбайд олборлолт явуулж 2,5 га газрыг эвдрэлд оруулсан
7	Жинхуа орд ХХК	6701А	Аудитын явцад 2013 оны БОМ-ийн төлөвлөгөө байгаагүй
8	Монфайненс ХХК	10646А	Аудитын явцад 2013, 2014 оны БОМ-ийн төлөвлөгөө байгаагүй
9	Лут чулуу ХХК	10206А	Аудитын явцад 2013 оны БОМ-ийн төлөвлөгөө байгаагүй
10	Си Эм Кэй Ай ХХК	4153А	Аудитын явцад 2013, 2014 оны БОМ-ийн төлөвлөгөө байгаагүй

Иймд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, барьцаа хөрөнгө байршуулаагүй, БОМ-ийн төлөвлөгөөний биелэлт гаргаагүй, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээлгэн өгөөгүй ААН-дэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох, хуульд нийцүүлэн ажиллуулах талаар арга хэмжээ авч зохион байгуулах хэрэгтэй байна.

Харин лицензээр олгогдоогүй талбайд ашигт малтмал олборлох явдлыг зогсоож буруутай этгээдэд “**Ашигт малтмалын тухай хууль**”-ийн 66.1.1⁹ дахь заалтыг баримтлан арга хэмжээ авах, аудитад хамрагдахаас зайлсхийсэн “Дорнын нүүрс” ХХК-нд Ашигт малтмалын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль” болон холбогдох стандарт хангагдаж буй эсэхэд холбогдох мэргэжлийн хүмүүсийг хамруулан шалгалт хийх шаардлагатай байна.

Мөн аудитад хамрагдахаас зайлсхийсэн аймгийн МХГ-ын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох нь зүйтэй юм.

3.3 Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг улсын комисс бүрэн хүлээн авсан байна.

Аймгийн БОАЖГ-ын даргаар ахлуулсан аймгийн МХГ-ын БОГУУХУАБайцаагч, аймгийн ЗДТГ-ын салбар хариуцсан мэргэжилтэн, БОАЖГ-ын газар, газрын хэвлий хариуцсан мэргэжилтэн, усны асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын төлөөлөл орсон комисс байгаль орчны нөхөн сэргээлтээр хийгдсэн ажлыг хүлээн авч байна.

⁹ 66.1.1.тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, ашигт малтмал олборлосон, борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, уг этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;


2013 онд аймгийн комисс 24,5 га-д техникийн, 10,3 га-д биологийн нөхөн сэргээлтийг, 2014 онд 13,2 га-д техникийн, 8,0 га-д биологийн, 1,5 га-д дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авч акт үйлдсэн нь баримтаар нотлогдож байна.

3.3 Уул уурхайн нөхөн сэргээлт хийсэн талбай нь холбогдох стандарт шаардлагыг хангасан байна.

Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд ашиглалт явуулж эхлэх үедээ газрын өнгөн хар хөрсийг холбогдох стандартын¹⁰ дагуу хуулан нөхөн сэргээлтийн үед буцаан ашиглах зорилгоор овоолго болгон бэлтгэсэн байна.

Аудитад хамрагдсан ААН-дээс 2013-2014 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт нь тухайн талбайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу, холбогдох стандартыг¹¹ баримтлан хийж гүйцэтгэжээ.

2013-2014 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг доорхи талбайд хийж гүйцэтгэсэн байна.



¹⁰ MNS 5917:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”

¹¹ MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн шаардлага”

Аудитын дүгнэлт 3

1. Орон нутгийн Төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагуудын “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 39.7¹ дэх заалтын хэрэгжилтэнд тавих хяналт хийгдэхгүй байна.
2. Тухайн жилд нөхөн сэргээлтээр хийгдсэн ажлыг аймгийн комисс хүлээн авсан байна.
3. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил холбогдох стандартын дагуу хийгдэж байна.
4. Тусгай зөвшөөрөлгүйгээр зарим ААН хууль бусаар ашигт малтмал олборлосон байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатар-т

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулаагүй ААН-дийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн ажиллуулах талаар ажил зохион байгуулах,
2. Хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-дийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулалтад тавих хяналтыг дээшлүүлэх,
3. Орон нутгийн төрийн байгууллагуудаас байгаль орчны нөхөн сэргээлтийн байдалд хийх хяналтыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ зохион байгуулах,

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сүнгээ-д

1. 2013-2014 онд нөхөн сэргээлт хийгээгүй, хүлээлгэн өгөөгүй ААН-ийн үйл ажиллагаанд шалгалт хийж, нөхөн сэргээлтийн хийлгэх,
2. Аудитад хамрагдахаас зайлсхийсэн “Дорнын нүүрс” ХХК-ны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт, нөхөн сэргээлт болон барьцаа хөрөнгө байршуулсан байдалд шалгалт хийх,
3. Лицензгүй талбайд олборлолт явуулсан ААН-дэд “Ашигт малтмалын тухай хууль”-д² заасан хариуцлагыг тооцож, нөхөн сэргээлтийг хийлгэх,

1. 39.7.Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.
2. 66.1.1.тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, ашигт малтмал олборлосон, борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, уг этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

Үндэсний Аудитын газарт тавих санал

5. БОНХАЖЯам нь уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахад удаашралтай байдаг зарим тохиолдолд батладаггүйгээс БОМ-ийн төлөвлөгөөгүйгээр ашигт малтмал олборлох байдал гарч байна.

Аудитын тайланд дурьдсан зөрчил дутагдлыг, арилгах чиглэлээр авах арга хэмжээ, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2015 оны 11-р сарын 20-ны дотор албан бичгээр, хийгдсэн ажил, үр дүнгийн талаарх мэдээллийг улирал тутам гаргаж ирүүлнэ үү.

ТАЙЛАН БИЧСЭН:

Шинжээч:

Д.Эрдэнэбилэг

2015 оны 11 сарын 02

Шалгагдагч байгууллагад хүргүүлсэн албан бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг бар
Утас: 70-56-21-47, Факс: (976) 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2015-10-22 № 210
танай -М № -Т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ж.ОЮУНБААТАР
ТАНАА

Үндэсний Аудитын газрын 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлж байна.

Аудитын тайлангийн хурал 2015 оны 10 сарын 26-нд болох тул саналаа энэ хугацаанаас өмнө ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХТҮВШИН

0600514

Шалгагдагч байгууллагаас ирсэн албан бичиг



2015. 10. 26 № 9/1638
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар танилцаж дүн шинжилгээ хийлээ.

Цаашид уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулах, үр дүнг дээшлүүлэх талаар салбарын холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллаж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил гаргасан төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудад зохих хууль, журмын дагуу хариуцлага тооцож ажиллах болно.

Иймд танай гаргасан дүгнэлт, тайланг дэмжих саналтай байна.



Ж.ОЮУНБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 41

Өндөрлаан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудаторуудад зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5, аймгийн Аудитын газрын Удирдах зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг ҮАГ-т тайлагнаж, аймгийн ИТХ-д танилцуулж, Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЦЭНХТҮВШИН

0300104



ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 11-р сарын 11

Дугаар № 14

Өндөрхаан хот

Эхэлсэн 10 цаг 15 мин

Дууссан 11 цаг 09 мин

Хурлыг Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин удирдан өөрийн албан тасалгаанд хийв.

Хуралдсан гишүүд: Ц.Энхтүвшин –тэргүүлэх аудитор
Б.Наранцэцэг – аудитын менежер
Ц.Хатанболд – аудитор

Оролцсон

Д.Эрдэнэбилэг - шинжээч
Г.Энхбаяр - Аймгийн БОАЖГ-ын дарга
Г.Мөнх-Эрдэнэ - Аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн
Ц.Цэрэндорж – Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн мэргэжилтэн
Г.Шараа – Аймгийн МХГ-ын Дэд бүтэц, байгаль орчин,
геологи уул уурхайн хяналтын хэлтсийн дарга

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.

СОНССОН НЬ:

Үндэсний Аудитын газрын 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт”-д 2015/09/01-10/25-ны хооронд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн хурал хийж байгаа талаар Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин танилцууллаа.

Шинжээч Д.Эрдэнэбилэг уг аудитаар аймгийн ЗДТГ, БОАЖГ, МХГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан, Бор-Өндөр, Норовлин сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 12 ААН-ийн нөхөн сэргээлт болон барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт зэрэгт газар дээр нь хяналт шалгалт хийсэн, бусад ААН-ийн үйл ажиллагааны талаар сумдаас болон холбогдох байгууллагуудаас мэдээллийг авч нэгтгэн аудит хийсэн талаар танилцууллаа. /Тайланг хавсаргав/.

- “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн аудитаар хэдийгээр хугацаа алдсан ч YAГ-аас зардлыг санхүүжүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой боллоо.
- Тайланд санал авахаар 2015.10.22-нд аймгийн ЗД-д албан тоот хүргүүлсэн боловч хуулийн хугацаа 10 хоногт багтаж саналаа ирүүлээгүй.
- Аймгийн МХГ, “Дорнын нүүрс” ХХК, аудитад хамрагдаагүй, нэр бүхий 9 ААН үйл ажиллагаа зөрчилтэй талаар мөн Баянмөнх, Жаргалтхаан, Батширээт, Баян-Адрага, Дадал, Норовлин, Баян-Овоо, Мөрөн, Хэрлэн сумд хайгуулын тусгай

зөвшөөрөл, барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын талаар мэдээлэл ирүүлээгүй.

Ц.Энхтүвшин: Удирдлагын Зөвлөлийн гишүүдэд тайлантай холбоотой асуух зүйл, санал байна уу?

Ц.Хатанболд: Тайлантай холбогдуулан асуух зүйлгүй

Б.Наранцэцэг: Тайлантай холбогдуулан асуух зүйлгүй

Ц.Энхтүвшин: “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн” аудиттай холбогдуулан шалгагдагч байгууллагын оролцогчдоос асуух зүйл байна уу?

Г.Энхбаяр: Байхгүй

Ц.Цэрэндорж: Надад нэг тайлбар байна

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалттай холбоотой аудитаар аймгийн ЗДТГ-аас ямар нэг баримт гаргаж өгөөгүй гэж байна. Үүнийг зөвшөөрөхгүй. Учир нь энэ талын бүх бичиг баримт аймгийн БОАЖГ-т байдаг бөгөөд аймгийн ЗДТГ-т энэ талын бичиг баримт байхгүй тул гаргаж өгөөгүй гэж хэлэх нь зохимжгүй юм.

Мөн аймгийн Засаг даргад 10 сарын 22-нд ирүүлсэн албан тоотыг өнөөдрийг хүртэл хараагүй тул үүнийг эргэн магадлая.

Эцэст нь аймгийн ЗД-д сумдаас уул уурхайн чиглэлээр хууль зөрчсөн талаар хүсэлт, санал, албан тоот, мэдээлэл ирээгүй тул хэрвээ ирвэл бид цаг хугацаанд нь асуудлыг шийддэг.

Г.Шараа: Би уул уурхайн ААН-дэд технологийн хяналт тавьдаг. Эдгээр зөрчилтэй ААН-үүд нь олон жил үйл ажиллагаа явуулж байгаа, хайрга, тоосгоны шавар зэрэг нь бүтээн байгуулалт тасалдах нь үйл ажиллагааг нь зогсоож болохгүй гэдэг.

Мөн Чандганы болон Хавтгайн нүүрсний уурхайг зөрчилтэй байна, зогсооно гэхээр аймаг гал алдах нь байна. Зогсоож болохгүй гээд он удаан жил ийм байдлаар явж байна. Ийым л тайлбар хэлэх байна.

Г.Мөнх-Эрдэнэ: Надад хэлэх зүйл алга.

Ц.Энхтүвшин: Өөр хэлэх зүйлгүй бол тайлангаа баталгаажуулах уу

Бүгд: Бүгд тайланг баталгаажуулах саналтай

Ц.Энхтүвшин: Тайланг өнөөдрийн хурлаар баталгаажуулж тушаал гаргая

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталъя, /Тушаал №41/

ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ЭНХТҮВШИН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ШИНЖЭЭЧ

Г.ДЭНЭЭБИЛЭГ



Хавсралт №1:

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

д/д	Аж ахуйн нэгж	Гаргасан зөрчил
1	Дорнын нүүрс ХХК	Аудитад хамрагдахаас зайлсхийсэн, нөхөн сэргээлтийн барьцаа тушаасан болон ААН-ийн мэдээлэл жагсаалтад байхгүй
2	ШШГЕГ-ийн харъяа хорих 0419-р анги	2013-2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй, барьцаа хөрөнгө байршуулаагүй
3	ШШГЕГ-ийн харъяа хорих 0419-р анги	Лицензгүй талбайгаас олборлолт явуулж 0.3 га-г эвдрэлд оруулсан
4	Жинхуа орд ХК	2013 оны БОМ-ийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө байршуулсан нь тодорхойгүй
5	Лут чулуу ХХК	2013 оны БОМ-ийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө байршуулсан нь тодорхойгүй
6	Си Эм Кэй Ай ХХК	2013 оны БОМ-ийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө байршуулсан нь тодорхойгүй
7	Мон файненс ХХК	2013-2014 оны БОМ-ийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө байршуулсан нь тодорхойгүй
8	Бэрх-Уул ХХК /Чандган/	2013-2014 оны БОМ-ийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө байршуулсан нь тодорхойгүй
9	Дацан трейд ХХК	2014 оны БОМ-ийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө байршуулсан нь тодорхойгүй
10	Бор-Өндөр УБҮ	2014 оны БОМ-ийн төлөвлөгөө батлуулаагүй, барьцаа хөрөнгө байршуулаагүй
11	Эзэнгүй	лицензээр олгогдоогүй талбайд олборлолт явуулж 2.5 га-г эвдрэлд оруулсан
12	Аймгийн МХГ	аудитад хамрагдахаас зайлсхийсэн
13	Сумдын Засаг дарга нар	Аудитад шаардлагатай материал гаргаж ирүүлээгүй